

Дүрслэн тайлбарласан эхийн
сэдэв , гол санаа, бүтцийг
тодорхойлох

Хичээлийн зорилго

- Эхийг ойлгож уншин, сэдэв, гол санааг тодорхойлох
- Дүрслэн тайлбарласан эхийн цогцолборын утгаар эхийн бүтцийг тодорхойлох

Дүрслэн бичсэн эхийн онцлог ямар байдгийг сэргээн саная

❑ Хөрөг найруулал \Гадаад, дотоод шинжийг тоочин бичих\

Зохиолч ямар нэгэн бие хүний амьдралд тохиолдсон гоц гойд зүйл, амжилт ололтыг тодруулан гаргахдаа, тэр хүний зан төлөв, төрх байдал, үйл ажиллагаа зэргийг өөрийн ажиглалт, судалгаанд үндэслэн дүрслэн бичсэн нийтлэлийг хөрөг найруулал гэнэ.

❑ Аян замын тэмдэглэл \Үйлийг тоочин дүрслэх \

Аян замд явахад тохиолдсон үйл, хэрэг явдлыг цаг хугацааны дарааллаар үнэн магадтай, үнэлж дүгнэж бичсэн эхийг хэлнэ.

Үйл, хэрэг явдлыг тайлбарлан бичнэ. Тохиолдсон бүхнээс хамгийн чухал, сонирхолтой гэж үзсэн зүйлээ сонгон авч бичих хэрэгтэй.

Аян замын тэмдэглэлийн ач холбогдол: Уншигчдыг шинэ сонин аян замд хөтөлнө. Уншигчдад аялсан газар орны онцлогийг таниулна. Байгалийн сайхан, газар нутгийн өвөрмөц дүр төрхийг тоочин дүрсэлж бичихдээ сонин содон дүрслэл, өвөрмөц үг хэллэг, тэмдэг нэр, дүрслэх дуурайх үгээ сонгож оновчтой хэрэглэнэ.



Хүн сайтыг олж нөхөрлө

“Сайн шувуу модоо шилж сууна. Сайн хүмүүн хүнээ олж нөхөрлөнө” гэх хуучны үг сургамжтай. Хүнийг нөхөрлөж буй хүнээр нь шинждэг нь аль ч үндэстэнд байдаг нийтлэг зүйл. Үүнийг монголчууд нөхрийг нөхрөөр нь шинж гэж хэлдэг. Хүнээ олж нөхөрлөх нь энэ яваа насны ээнэгшин ижилдэх эрхэм үйлсийн оргил билээ. Нэгэн биений нөхөр, нимгэн хувцасны нөмөр болох хүнээ таньж олох нь залуу хүн чиний хувьд амьдралдаа хийх амжилттай сонголтын нэг яах аргагүй мөн. Яагаад гэвэл, нөхрийн сайнаар хүн өөдлөж, нуурын сайнаар загас жаргаж явдаг гэдэг. Хүн хүнийхээ хүчинд, загас усныхаа хүчинд байдаг болохоор ийм байх нь аргагүй ээ. Нөмөр сайтай гэр дулаан байдгийн адил нөхөр сайтай хүн нөмөр нөөлөгтэй байна.

Алаг хорвоогийн амьдрал баян болохоор аян замын уртад ачлах сайн нөхөр таарахын зэрэгцээ аман дээрээ сүрхий, ачир дээрээ базаахгүй нь ч уулзана. Тус болох нөхөр гурав, ус болох нөхөр гурав байдаг тухай дорнын нэгэн сэтгэгчийн сургаал бий. “Тус болох нь шулуун нөхөр, шударга нөхөр, ихийг дуулсан нөхөр болно. Ус болох нөхөр нь нүүр тал засагч, зусар бялангач, цуурхай задгай амт нөхөр болой” гэжээ. Тус болох нөхөртэй үй зайгүй найзалж, ус болох нөхрөөс үүдэн хоймрын зай барьж яв. Өгөө аваан дээр суурилсан нөхөрлөл өнө удаан тогтохгүй. “Өөрийн үйлийг бүтээх төдий нөхөрлөх аминч хүнтэй өнө сайтар ханилан явахад ер бэрх” гэж бидний өвөг дээдэс анхааруулж хэлснийг өнөө цаг үед бүр ч илүү санууштай.

Тэнэг нөхөр тээг садаа болно. “Тэнэг нөхрөөс ухаантай дайсан дээр” гэсэн үнэн үг бий. “Тэнэг хүн харагдах гэж урд нь бултаганана. Ухаантай хүн харах гэж ард нь үлдэнэ”.

Үргэлжлэл

Сайн нөхрөө харж саар талаа зас. Дотно нөхрөө урмаар тэтгэж, сэтгэлийн тэнхээ хайрлаж сурах нь нөхөрлөл батжих нэг үндэс. Хүн гар татуу, сэтгэл дутуу байхыг алийг тэр гэх вэ. Гэхдээ нөхрөө дэмнэн, сэтгэлийг засах урам магтаалын үгэндээ татуу, дутуу байж яавч болохгүй. Нөхдийн ололтыг дэмжиж, магтан сайшаахын хамт, дутууг гүйцээж, дутагдлыг хэлж өгөх чухал .

“Гаргасан алдааг минь хэн зөвөөр хэлнэ вэ тэр миний багш.Хэрэг явдлын минь үнэнийг хэн шударгаар тэмдэглэнэ, тэр миний нөхөр, надад хэн зусардана, тэр миний дайсан” (Сюнь Цзы) гэсэн дорнын мэргэн үг хэн нөхөр, хэн дайсан болохыг ялгаж танихад тусална. Хүн сайтыг олж нөхөрлөвөл хүний хорвоод магнай тэнэгэр, магад жаргалтай амьдарна.

(Н.Багабанди” Титэм үг”)



Эхийн утгыг ярилцъя

- ☐ Эхийн сэдэв нь юу вэ? Эхэд юуны тухай өгүүлэв?
- ☐ Эхийн дэвшүүлсэн асуудал юу вэ?
- ☐ Эхийн гол санаа?
- ☐ Бичсэн аргын хувьд дүрсэлсэн үү? Тайлбарласан уу?
- ☐ Зохиогчийн бичсэн зорилго нь ямар байна?
- ☐ Зохиолчийн чухалчилсан санаа нь юу вэ?

Эхийн сэдэв:

Эхэд өгүүлэгдэж байгаа гол юмнаас үүдэлтэй санааг сэдэв гэнэ. Юуны тухай? гэсэн асуултаар илрүүлнэ.

Эхэд дэвшүүлсэн асуудал:

Тухайн сэдвийн хүрээнд илэрч буй шийдвэрлэх шаардлагатай асуудлыг хэлнэ.

Эхийн гол санаа:

Сэдэв болон дэвшүүлсэн асуудлын хүрээнд гаргасан дүгнэлт санааг хэлнэ.

Түлхүүр үг: Эхэд олон давтагдаж орсон, гарч буй хэрэг явдлын санааг бүтээхэд чухал үүрэгтэй үгийг хэлнэ.

Эхийн утгыг ойлгох

Эхийн агуулгын бүтэц	Цогцолборын дугаар	Цогцолборын утга санаа	Эхийн гол санаа
Эхлэл хэсэг	1-р цогцолбор	Монголчууд хүнийг нөхрөөр нь шинж гэж хэлдэг	Хүн сайтыг олж нөхөрлө” эхэд нөхрийн сайнаар хүн өөдөлж, нуурын сайнаар загас жаргаж явдаг шиг найз нөхдөө зөв сонгон нөхөрлөх нь чухал. Сайн нөхөр амьдралын түшиг тулгуур бол муу найз үргэлж тээг саад болдог юм гэдгийг ойлгуулахын тулд тайлбарлан бичсэн.
	2-р цогцолбор	Найз нөхрөө зөв сонгож нөхөрлө	
Гол хэсэг	3-р цогцолбор	Сайн нөхөр амьдралын түшиг тулгуур бол муу найз үргэлж тээг саад болдог	
Төгсгөл хэсэг	4-р цогцолбор	Хүний сайтыг олж нөхөрлөвөл хүний хорвоод магнай тэнэгэр , магад жаргалтай амьдарна.	

“Хүн сайтыг олж нөхөрлө”

Хэлц	Уран дүрслэл	Гол буюу тайлбарласан хэсэг
Нэгэн биеийн нөхөр Нимгэн хувцасны нөмөр	Адилтгал , тойруулал	Нөмөр сайтай гэр дулаан байдгийн адил нөхөр сайтай хүн нөмөр нөөлөгтэй байна.
Нөхрийн сайнаар хүн өөдөлнө Нуурын сайнаар загас жаргана	Адилтгал	Яагаад гэвэл, нөхрийн сайнаар хүн өөдөлж, нуурын сайнаар загас жаргаж явдаг гэдэг
Хүн хүнийхээ хүчинд Загас усныхаа хүчинд		
Аман дээрээ сүрхий Ачир дээрээ базаахгүй		
Тэнэг нөхөр тээг садаа болно		
Тэнэг хүн харагдах гэж урд нь бултганана Ухаантай хүн харах гэж ард нь үлдэнэ		

“Хүн сайтыг олж нөхөрлө”

Хэлц	Уран дүрслэл	Хэлцийн гол санаа
Нэгэн биеийн нөхөр Нимгэн хувцасны нөмөр	Адилтгал , тойруулал	Нөмөр сайтай гэр дулаан байдгийн адил нөхөр сайтай хүн нөмөр нөөлөгтэй байна.
Нөхрийн сайнаар хүн өөдөлнө Нуурын сайнаар загас жаргана	Адилтгал	Найз нөхрөө зөв таньж нөхөрлөснөөр хүн өөдөлж, дэвжинэ.
Хүн хүнийхээ хүчинд Загас усныхаа хүчинд	Адилтгал	Хүн хүнийхээ тус дэмээр амьдардаг
Аман дээрээ сүрхий Ачир дээрээ базаахгүй	Адилтгал	Хэлэх нь сайхан ч,хийх нь өөр ,сайхан ярьдаг ч үр дүн багатай.
Тэнэг нөхөр тээг садаа болно	Адилтгал	Тэнэг хүн амьдралд саад болох, тэнэг хүн тээг саадтай адил
Тэнэг хүн харагдах гэж урд нь бултганана Ухаантай хүн харах гэж ард нь үлдэнэ	Адилтгал	Тэнэг хүн өөрийгөө дөвийлгөж таниулахыг хичээдэг бол ухаантай хүн яарч үйлдэл хийдэггүй , аливаад буурьтай, бодолтой ханддаг.



Адилтгал:

Юмс үзэгдлийн аль нэг шинжийг товойлгон тодруулах зорилгоор түүнтэй төстэй өөр юм үзэгдлийн нэрээр утга шилжүүлэн дүрслэх найруулгын ур маяг юм.Адилтгал бол далд зүйрлэл юм.

Дүрслэн тайлбарласан эх

Дүрслэн тайлбарлаж бичихдээ дүрслэл ашиглах нь уншигчийн сонирхлыг татаад зогсохгүй уг эхэд илэрхийлж буй санааг илүү тодорхой болгодог. Ийм эхийг дүрслэн тайлбарласан эх гэдэг.

Дүрсэлж тайлбарлана гэдэг нь аливаа мэдээлэл тайлбарыг өгөхдөө уран сайхны дүрслэлээр дамжуулан тайлбарладаг байна.

1. Жишээ нь: Н.Багабандийн “ Хүн сайтыг олж нөхөрлө” эхэд нөхрийн сайнаар хүн өөдөлж, нуурын сайнаар загас жаргаж явдаг шиг найз нөхдөө зөв сонгон нөхөрлөх нь чухал. Сайн нөхөр амьдралын түшиг тулгуур бол муу найз үргэлж тээг саад болдог юм гэдгийг ойлгуулахын тулд тайлбарлах зорилгоор бичсэн. Ингэхдээ өгүүлбэрийг хэлэх аялгаар хэм тэнцүүлэн, толгой сүүл холбох, хэлц, зүйр цэцэн үгийг ашиглах гэх мэтээр дүрслэлийн олон аргыг ашиглан бичсэн байна.

Анхаарал тавьсанд баярлалаа

